



Шалгалтын захиалга өгөх, өөрчлөх, цуцлах тохиолдолд:

Бүртгэл үүсгэх

Нэвтрэх

- Нэвтрэх нэрээ мартсан бол
- Нууц үгээ мартсан бол

[Шалгалтын төв хайх](#) [Шалгалтыг харах](#) [Шалгалт өгөхөд анхаарах зүйлс](#) [Холбоо барих](#)

JBMA Японы Барилга засвар үйлчилгээний холбоо

Барилга цэвэрлэгээний Тусгай ур чадварын 1-р зэргийн үнэлгээний шалгалтын тухай

Оршин суух зөвшөөрөл “Тусгай ур чадварын 1-р зэрэг (барилгын цэвэрлэгээ)-ээр Япон Улсад ажиллах хүсэлтэй хүн өгдөг ур чадварын шалгалт юм.

Барилгын цэвэрлэгээний талаарх ур чадвар болон мэдлэгийг шалгах болно.

Шалгалт өгөх эрх

- Шалгалт өгөх өдөр 17 нас ба түүнээс дээш насанд хүрсэн байх. Харин Индонези иргэншилтэй бол шалгалт өгөх өдөр 18 нас ба түүнээс дээш насанд хүрсэн байх.
- Японд шалгалт өгөх хүн бол хүчинтэй хугацаатай оршин суух эрхтэй байх.

Шалгалтын агуулга болон шалгалтын цаг

Шалгалт нь бичгийн шалгалт болон ур чадварын практикийн шалгалтаас бүрдэнэ. Бүх шалгалт Япон хэлээр явагдана.

Бичгийн шалгалт: Дасгал ажлын тоо 20 асуумж, (Нийт онооны 60-аас дээш хувьтай бол тэнцэнэ), шалгалтын хугацаа 20 минут

Ур чадварын практикийн шалгалт: Дасгал ажлын тоо 30 асуумж, (Нийт онооны 60-аас дээш хувьтай бол тэнцэнэ), шалгалтын хугацаа 30 минут

Мөн нийт 50 минутын шалгалтаас гадна Нууцыг хадгалах гэрээг зөвшөөрөх, Зааварчилгаа, Санал асуулга бөглөхөд дахин 10 минут шаардлагатай.

Шалгалтын хураамж

Японд шалгалт өгөх тохиолдолд: 4,400 иен (10% Хэрэглээний татвар багтсан болно)

Японоос өөр улсад шалгалт өгөх тохиолдолд: 30 ам.доллар

Цахим бүртгэл, захиалга өгөх, шалгалт өгөх явц

Алхам 1: Шинэ хэрэглэгчийн бүртгэл үүсгэх (Бүртгэл үүсгэх)

Барилгын цэвэрлэгээний тусгай ур чадварын 1-р зэргийн үнэлгээний шалгалтыг “Pearson VUE”-ээр өгөхийн тулд та шинээр хэрэглэгчийн бүртгэл үүсгэх шаардлагатай. “Бүртгэл үүсгэх” дээр дарж , дэлгэцийн зааврын дагуу хэрэглэгчийн бүртгэл үүсгэнэ үү. Хэрэв та бүртгэлтэй бол Алхам 2-руу шилжинэ үү.

※ Таны бүртгүүлсэн овог нэр нь шалгалт өгөх өдөр шалгалтын байранд таны үзүүлэх тухайн хүнийг

батлах бичиг баримт дээрх нэрээс өөр байвал шалгалтад оруулахгүй болохыг анхаарна уу.

Анхааруулга

2026 оны 3-р сарын 31-ний өдөр хүртэл бүртгүүлэх боломжтой. 2026 оны 4-р сарын 1-ний өдрөөс хойш систем дээр захиалга хийх боломжтой боловч захиалга хийхгүй байхыг хүсье.

Алхам 2: Шалгалт өгөх захиалга

Алхам 1-ээр бүртгүүлсэн хэрэглэгчийн нэр болон нууц үгээ оруулан шалгалтын захиалгаа өгнө үү.

※ Та ваучертай бол төлбөрийн болон нэхэмжлэхийн мэдээлэл оруулах дэлгэц дээрх "Ваучер эсвэл урамшууллын код нэмэх" дээр дарж, ваучерын дугаараа оруулан "хэрэглэх" дээр дарж захиалгаа бүрэн дуусгана уу.

※ Захиалга дууссаны дараа танд захиалга баталгаажуулсан и-мэйл ирэх болно.

Захиалгын сүүлийн хугацаа, захиалга өөрчлөх, цуцлах сүүлийн хугацаа

- **Захиалга өгөх сүүлийн хугацаа:** Шалгалт өгөхийг хүссэн өдрийн өмнөх өдрийн 23цаг 59минут хүртэл
- **Захиалга өөрчлөх, цуцлах сүүлийн хугацаа:** Одоогийн захиалгын огноо цагаас 24 цагийн өмнө хүртэл

Анхааруулга: Бүх сүүлийн хугацаа нь цахим захиалгын сайт дээрх сүүлийн хугацаа болно. Хэрэв та Харилцагчийн үйлчилгээгээр дамжуулан захиалга хийх, захиалгаа өөрчлөх, цуцлахыг хүсвэл холбогдох хугацаа болон Харилцагчийн үйлчилгээний ажиллах цагийн үеэр дуусгах шаардлагатай. Захиалгыг сүүлийн хугацаа дууссаны дараа өөрчлөх эсвэл цуцлах боломжгүй.

Төлбөр төлөх арга

Шалгалтын хураамжийг зөвхөн кредит карт болон ваучераар төлөх боломжтой.

- Кредит карт
VISA、Master、JCB、AMEX тус тус ашиглах боломжтой.
- Урьдчилсан төлбөрийн ваучер

Компани эсвэл сургууль шалгалтын төлбөрийг хариуцах тохиолдолд урьдчилсан төлбөрийн ваучер ашиглах боломжтой. Гэхдээ хамгийн багадаа 10 шалгалтын эрх (10 хүн) худалдан авах боломжтой юм. Урьдчилсан төлбөрийн ваучерыг хэрхэн худалдаж авах талаарх дэлгэрэнгүй мэдээллийг доорх линкээс лавлана уу. Урьдчилсан төлбөрийн ваучер худалдаж авсны дараа шалгалтад хамрагдах хүн бүрд ваучерын дугаараа тараана уу.

(Японд шалгалт өгөх тохиолдолд) Ваучер стор ※ Доод худалдан авах тоо: 10 шалгалтын эрх～

(Японоос өөр улсад шалгалт өгөх тохиолдолд) Purchase Vouchers ※ Доод худалдан авах тоо: 1шалгалтын эрх～

Алхам 3:

Шалгалт өгөх өдөртөө бэлдэхийн тулд доорх хуудаснаас бэлдэх зүйл, явцтай танилцана уу.

- Шалгалт өгөхийн өмнө бататгах зүйлс
Шалгалт өгөхийн өмнө бататгах зүйлс (Япон хэл)

Helpful resources for test-takers (English)

- Шалгалтын өдөр Шалгалтын төв дэх ерөнхий үйл явц (видео)
Шалгалт өгөх явц (Япон хэл)
What to expect when testing with Pearson VUE (English)
- “CBT” хувилбарын демо шалгалт
Демо шалгалт (Япон хэл)

Алхам 4: Шалгалт өгөх

Байранд ирэх цаг

Шалгалт өгөх өдөр шалгалт эхлэхээс 15-аас доошгүй минутын өмнө шалгалтын байранд хүрэлцэн ирж бүртгэлээ дуусгана уу. Хоцорсон тохиолдолд шалгалтад оруулахгүй, шалгалтын хураамжийг буцаан олгохгүй болно.

Авч ирэх зүйл

Бүртгүүлэхдээ **тухайн хүнийг мөн эсэхийг батлах боломжтой хүчинтэй 1 бичиг баримт үзүүлэх шаардлагатай**. Дэлгэрэнгүй мэдээллийг доорх хуудаснаас лавлана уу. "Захиалга дээрх овог нэр" болон "Бичиг баримт дээрх овог нэр" хоёр өөр байвал шалгалтад оруулахгүй болно. Нэр тохироогүйн улмаас шалгалт өгөх эрхгүй болбол шалгалтын хураамжийг буцаан олгохгүй.

(Японд шалгалт өгөх тохиолдолд) Тухайн хүнийг батлах бичиг баримтын тухайд ※Японд шалгалт өгөх бол гадаад паспортоо авчирна уу.

(Японд шалгалт өгөх тохиолдолд) Global ID Policy 1 ※ Гадаад Паспорттай бол гадаад паспортоо авчирна уу.

Шалгалтын танхимд хувийн эд зүйл авч орох боломжгүй. Шалгалт өгөхдөө шаардлагагүй зүйл авчрахгүй байхыг зөвлөж байна.

Бүртгэлийн үеэр ламинатор бүхий цагаан дэвтэр, үзэг (түргэн хатдаг усан суурьтай үзэг) тараах тул шалгалтын үед тэмдэглэл хөтлөх боломжтой. Шалгалтын дараа цагаан дэвтэр болон үзгийг буцаан авна.



Нууцыг хадгалах гэрээ (NDA)-г хүлээн зөвшөөрөх

Шалгалтын төвд шалгалт эхлэхийн өмнө та Нууцыг хадгалах гэрээг (NDA) зөвшөөрөх шаардлагатай. NDA нь голчлон асуулт, хариултын агуулгыг гуравдагч этгээдэд задруулахгүй байх гэрээ юм. Хэрэв та зөвшөөрөхгүй бол шалгалтаа эхлүүлэх боломжгүй болно. Мөн үл зөвшөөрөн шалгалт өгөхгүй бол шалгалтын хураамжийг буцаан олгохгүй. Хэрэв шалгалт өгсний дараа та гэрээний зүйлд харшлах ямар нэгэн хориотой үйлдэл хийсэн болох нь батлагдвал гэрчилгээ олгох байгууллага таны мэргэшлийн гэрчилгээг цуцалж, цаашид шалгалт өгөхийг хориглох зэрэг арга хэмжээ авах болно.

Алхам 5: Шалгалтын дүн

Бид танд дараах хоёр аргаар шалгалтын дүнг мэдэгдэх болно.

- **Онооны тайлан**

Шалгалт өгсний дараа Шалгалтын төвд онооны тайланг (тэнцсэн / эс тэнцсэн) шууд хэвлэн танд гардуулах болно. Та дараа нь “Pearson VUE” хэрэглэгчийн “Миний хуудас”-аас ижилхэн онооны тайланг харах боломжтой.

Анхааруулга: Онооны тайлан нь тэнцсэн гэх гэрчилгээ биш болно.

- **Шалгалтад тэнцсэн гэрчилгээ**

Шалгалтад тэнцэгч болон хүлээн авагч байгууллагын хооронд хөдөлмөрийн гэрээ байгуулахаар шийдвэрлэсний дараа Японы барилга засвар үйлчилгээний холбоонд гэрчилгээ авах хүсэлтээ гаргаж, гэрчилгээ олгох 11,000 иен (хэрэглээний 10 хувийн татвар багтсан) -ий төлбөрийг төлсний дараа гэрчилгээг хүлээн авагч байгууллагад олгоно.

Анхаарах зүйлс

Зүй зохисгүй үйлдэл, арга хэрэгслээр шалгалт өгөхийг завдсан, эсвэл шалгалт өгсөн хүн таван жил хүртэл хугацаагаар шалгалт өгөх эрхгүй болно.

Хэрэв та зүй зохисгүй арга замаар шалгалт өгсөн бол бид таны шалгалтад тэнцсэнийг цуцалж, гэрчилгээг буцааж өгөхийг шаардах болно. Мөн шалгалтын хураамж болон гэрчилгээ олгох хураамжийг буцаан олгохгүй болохыг анхаарна уу.

Хувь хүний мэдээлэл

Шалгалтад бүртгүүлсэн болон Шалгалтын төвд хүлээн авсан хувь хүний мэдээллийг Японы Барилга засвар үйлчилгээний холбооны хувийн мэдээллийг хамгаалах журамд үндэслэн шалгалт өгөх, тэнцсэн гэрчилгээ олгох, тусгай ур чадварын тогтолцоог судлан үзэх зорилгоор ашиглана. Түүнчлэн хувь хүний мэдээллийг Япон Улс эсвэл өргөдөл гаргагчийн иргэншил болох улсын захиргааны байгууллагад өгөх тохиолдол байдаг.

Нийтийн ашиг сонирхлын холбоо Японы Барилга засвар үйлчилгээний холбоо

Шалгалтын захиалга өгөхтэй холбоотой түгээмэл асуултууд

Шалгалтын өдөр Шалгалтын төв дэх үйл явц

- Холбоо барих

Лавлах зүйлийн агуулгаас хамааран холбоо барих газар нь өөр байх тул анхаарна уу.

Лавлах зүйлийн агуулга	Холбоо барих газар
● Бүртгэл үүсгэх, захиалга өгөх арга, захиалга дууссаныг мэдэгдэх и-мэйлийн талаар ● Хувь хүнийг батлах бичиг баримтын талаар ● Бүртгэл үүсгэсний дараа овог нэр өөрчлөх талаар ● Шалгалт өгөх газар (Шалгалтын төв) -ын хүн дүүргэлтийн байдлын талаар	Pearson VUE Харилцагчийн үйлчилгээ https://www.pearsonvue.com/us/en/test-takers/customer-service/email.html
● Шалгалтын агуулгын талаар ● Шалгалт өгөх эрх болон нөхцөлийн талаар ● Шалгалтын дүнгийн талаар ● Шалгалтад тэнцсэн гэрчилгээ олгох талаар	Нийтийн ашиг сонирхлын холбоо Японы Барилга засвар үйлчилгээний холбоо И-мэйл: tokuteiginou@j-bma.or.jp